**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.10.16 № 1/5363

танай 2023.10.06-ны № 03/2525-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2023 оны А/130 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6448 дугаарт, “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай” 2023 оны А/136 дугаар тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6449 дугаарт тус тус бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

15160 4855

Doc.yam a5.2023

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 10 сарын 16-ны өдрийн 6449 дугаарт бүртгэв.

**МОНГОЛ УЛСЫН**
**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН**
**САЙДЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 05 өдөр Дугаар А/136 Улаанбаатар хот

Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил,
мэргэжлийн жишиг цалин батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тэтгэвэр тогтооход баримтлах “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин”-г хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/136 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД Х.БУЛГАНТУЯА

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТЭАГҮҮГ
ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Гарын үсэг
20 23 он 10 сар 05 өдөр

151230353

D: 2023 on 09 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/136 дугаар тушаалын хавсралт

## ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЖИШИГ ЦАЛИН

(төгрөгөөр)

| № | Үндсэн бүлэг | 1990 он ба түүнээс өмнөх | 1991 он | 1992 он | 1993 он | 1994 он |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Менежер | 800 | 1600 | 2800 | 7100 | 12600 |
| 2 | Мэргэжилтэн | 650 | 1300 | 2250 | 5700 | 10200 |
| 3 | Техникч болон туслах, дэд мэргэжилтэн | 580 | 1160 | 2000 | 5060 | 9050 |
| 4 | Контор, үйлчилгээний ажилтан | 450 | 900 | 1540 | 3850 | 7850 |
| 5 | Худалдаа, үйлчилгээний ажилтан | 430 | 860 | 1470 | 3650 | 6500 |
| 6 | Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан | 420 | 840 | 1430 | 3550 | 6350 |
| 7 | Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан | 510 | 1020 | 1750 | 4400 | 7850 |
| 8 | Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч | 550 | 1100 | 1900 | 4800 | 8500 |
| 9 | Энгийн ажил, мэргэжил | 350 | 700 | 1200 | 2900 | 5150 |
| 10 | Зэвсэгт хүчний ажил мэргэжил | 600 | 1200 | 2080 | 5250 | 9350 |

---oOo---

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТЭАГҮҮГ
ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Гарын үсэг:
2023 он 10 сар 06 өдөр